

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Аудитор: Б.Энхмандал  
Утас: 70453799, Цахим хаяг: Enkhmandal.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ДАВСТ СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
С.БАТМАГНАЙ ТАНАА

2022.02.25 № УВА-2022/94/НА-СТА-143  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Давст сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
С.БАТСУУРЬ

0200200334

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Тогроогоор/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,272,351.38</b>	<b>16,341,316.76</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	32,900.00	3,665.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	32,900.00	3,665.38
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	17,239,451.38	16,337,651.38
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	17,239,451.38	16,337,651.38
35410	Бичиг хэргийн материал	1,352,900.00	964,100.00
35420	Аж ахуйн материал	15,886,401.00	15,373,401.00
35440	Түлш, шатах тослох материал	150.38	150.38
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,018,290,901.50</b>	<b>1,981,515,712.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,018,290,901.50	1,981,515,712.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,013,507,401.50	1,976,762,212.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,011,228.00	1,763,011,228.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,920,567.68	-38,304,088.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,402,543.60	63,402,543.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,947,414.32	-26,506,999.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,292,526.50	49,292,526.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,270,735.78	-14,922,819.18
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	169,466,425.00	169,466,425.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,799,999.62	-4,000,000.00
39217	Ном	11,273,395.80	11,323,395.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,783,500.00	4,753,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,500.00	-22,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,806,000.00	4,806,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-30,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,035,563,252.88</b>	<b>1,997,857,029.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>614,668.00</b>	<b>243,990.74</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	614,668.00	243,990.74
<b>413</b>	<b>Өглөг</b>	614,668.00	243,990.74
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	614,668.00	243,990.74
41361	Байгууллагад төлөх өглөг	612,268.00	243,990.74
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,400.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,034,948,584.88</b>	<b>1,997,613,038.30</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,034,948,584.88	1,997,613,038.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	272,796,363.80	272,796,363.80
51101	Өмч: - төрийн	272,796,363.80	272,796,363.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,413,180,337.65	1,375,844,791.07
51210	Өмнөх үеийн үр дүн	1,413,180,337.65	1,413,180,337.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-37,335,546.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348,971,883.43	348,971,883.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,035,563,252.88</b>	<b>1,997,857,029.04</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,670,537,208.20</b>	<b>153,825,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,541,692,708.20</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,541,692,708.20	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,541,692,708.20	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,541,502,708.20	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>128,844,500.00</b>	<b>153,825,400.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	128,844,500.00	153,825,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,844,500.00	153,825,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>133,788,260.63</b>	<b>191,160,946.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>133,788,260.63</b>	<b>191,160,946.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	132,514,782.63	179,823,975.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,876,256.39	57,325,326.00
210101	Үндсэн цалин	55,836,256.39	51,368,504.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,956,822.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,423,510.00	7,121,190.62
210201	Тэтгэврийн даатгал	3,456,878.00	4,163,251.52
210202	Тэтгэмжийн даатгал	508,485.00	1,376,319.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	714,204.00	412,991.76
210204	Ажилгүйдлийн даатгал	545,960.00	136,148.05
210205	Эрүүл мэндийн даатгал	2,197,983.00	1,032,479.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,178,571.00	73,226,670.00
210301	Гэрэл, цахилгаан	1,014,519.00	1,230,168.00
210302	Түлш, халаалт	46,139,252.00	71,996,502.00
210303	Цэвэр, бохир ус	24,800.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,628,300.00	1,378,200.00
210401	Бичиг хэрэг	1,009,400.00	508,900.00
210402	Тээвэр, шатахуун	704,500.00	335,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	554,400.00	333,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	97,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	97,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	230,000.00	2,165,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	83,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	183,300.00

210604	Урсгал засвар	230,000.00	1,898,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	350,000.00	128,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	128,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	430,280.00	372,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,000.00	156,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	266,000.00	00.00
210807	Газрын төлбөр	29,280.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,397,865.24	38,009,189.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,184,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,397,865.24	36,825,189.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,273,478.00	11,336,970.74
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	299,940.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	299,940.00	250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	973,538.00	11,086,970.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	973,538.00	11,086,970.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,536,748,947.57</u></b>	<b><u>-37,335,546.58</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,536,748,947.57</u></b>	<b><u>-37,335,546.58</u></b>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>129,034,500.00</b>	<b>153,825,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>190,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	190,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>128,844,500.00</b>	<b>153,825,400.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	128,844,500.00	153,825,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,844,500.00	153,825,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>129,034,500.00</b>	<b>153,825,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>129,034,500.00</b>	<b>153,825,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>127,760,962.00</b>	<b>142,488,429.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	61,631,311.00	57,263,869.26
210101	Үндсэн цалин	56,591,311.00	52,223,869.26
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,714,558.00	7,400,990.00
210201	Тэтгэврийн даатгал	3,392,358.00	5,119,938.32
210202	Тэтгэмжийн даатгал	547,600.00	570,262.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	473,200.00	456,210.25
210204	Ажилгүйдлийн даатгал	118,300.00	114,052.67
210205	Эрүүл мэндийн даатгал	1,183,100.00	1,140,525.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,410,912.00	73,226,670.00
210301	Гэрэл, цахилгаан	818,539.00	1,230,168.00
210302	Түлш, халаалт	46,592,373.00	71,996,502.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,788,901.00	937,900.00
210401	Бичиг хэрэг	489,901.00	204,100.00
210402	Тээвэр, шатахуун	704,500.00	337,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,200.00
210404	Ном, хэвлэл	59,500.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,000.00	145,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,000,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,530,000.00	1,691,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	83,700.00



210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	83,300.00
210604	Урсгал засвар	3,200,000.00	1,524,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>350,000.00</b>	<b>128,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	350,000.00	128,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,335,280.00</b>	<b>1,740,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,000.00	1,524,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	566,000.00	00.00
210807	Газрын төлбөр	29,280.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,273,538.00</b>	<b>11,336,970.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>250,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>973,538.00</b>	<b>11,086,970.74</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	973,538.00	11,086,970.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>272,796,363.80</b>	<b>348,971,883.43</b>	162,160,308.28	783,928,555.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,251,020,029.37	1,251,020,029.37
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>272,796,363.80</b>	<b>348,971,883.43</b>	<b>1,413,180,337.65</b>	2,034,948,584.88
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>272,796,363.80</b>	<b>348,971,883.43</b>	<b>1,413,180,337.65</b>	2,034,948,584.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>272,796,363.80</b>	<b>348,971,883.43</b>	<b>1,413,180,337.65</b>	2,034,948,584.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-37,335,546.58	-37,335,546.58
D09	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>272,796,363.80</b>	<b>348,971,883.43</b>	<b>1,375,844,791.07</b>	1,997,613,038.30

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/тогроогоор/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		ЗӨРҮҮ	ХУВЬ
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	153,825,500.00	142,738,429.26	11,087,070.74	92.79
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	153,825,500.00	142,738,429.26	11,087,070.74	92.79
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	153,575,500.00	142,488,429.26	11,087,070.74	92.78
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	57,313,500.00	57,263,869.26	49,630.74	99.91
210101	Үндсэн цалин	52,273,500.00	52,223,869.26	49,630.74	99.91
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00	00.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,737,400.00	7,400,990.00	336,410.00	95.65
210201	Тэтгэврийн даатгал	5,444,400.00	5,119,938.32	324,461.68	94.04
210202	Тэтгэмжийн даатгал	573,600.00	570,262.92	3,337.08	99.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	458,500.00	456,210.25	2,289.75	99.50
210204	Ажилгүйдлийн даатгал	114,600.00	114,052.67	547.33	99.52
210205	Эрүүл мэндийн даатгал	1,146,300.00	1,140,525.84	5,774.16	99.50
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,922,200.00	73,226,670.00	10,695,530.00	87.26
210301	Гэрэл, цахилгаан	1,937,500.00	1,230,168.00	707,332.00	63.49
210302	Түлш, халаалт	81,984,700.00	71,996,502.00	9,988,198.00	87.82
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	937,900.00	937,900.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	204,100.00	204,100.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	337,800.00	337,800.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	200,200.00	00.00	100.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	145,800.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	100,000.00	100,000.00	00.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	00.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,691,000.00	1,691,000.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	83,700.00	00.00	100.00



210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	83,300.00	00.00	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	1,524,000.00	1,524,000.00	00.00	<b>100.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	133,500.00	128,000.00	5,500.00	<b>95.88</b>
210702	Дотоод албан томилолт	133,500.00	128,000.00	5,500.00	<b>95.88</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,740,000.00	1,740,000.00	00.00	<b>100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,524,000.00	1,524,000.00	00.00	<b>100.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	00.00	<b>100.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	250,000.00	250,000.00	00.00	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	250,000.00	250,000.00	00.00	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	250,000.00	00.00	<b>100.00</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	153,825,500.00	142,738,429.26	11,087,070.74	<b>92.79</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	153,825,500.00	142,738,429.26	11,087,070.74	<b>92.79</b>
132001	Орон нутгийн төсвөөс	153,825,500.00	142,738,429.26	11,087,070.74	<b>92.79</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	06.00	06.00	00.00	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	<b>100.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	00.00	<b>100.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	00.00	<b>100.00</b>
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	00.00	<b>100.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхмандал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Давст сумын Соёлын төв нь “Үндэсний соёлыг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сэргээн хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 191.1 сая төгрөгийн 1 хувь буюу 1.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Давст сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,706.2 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	32.9	3.6	30.0
Бараа материал	17,239.4	16,337.6	901.8
Үндсэн хөрөнгө	2,018,290.9	1,981,515.7	36,775.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,035,563.2</b>	<b>1,997,857.0</b>	<b>37,706.2</b>
Өр төлбөр	614.6	243.9	370.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,034,948.5	1,997,613.0	37,335.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,035,563.2</b>	<b>1,997,857.0</b>	<b>37,706.2</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16,337.6 мянган төгрөг болж 901.8 мянган төгрөгөөр буурсан нь 616.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,793.8 мянган төгрөгийн аж ахуйн материалын зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,981,515.7 мянган төгрөг болж 36,776.0 мянган төгрөгөөр буурсан нь 36,825.1 мянган төгрөгийн тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 50.0 мянган төгрөгийн номын фонтоор нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,997,613.0 мянган төгрөг болж 37,335.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ. Үүнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,516,711.8 мянган төгрөгөөр буюу 90.8 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх онд шинэ Соёлын төв баригдаж ашиглалтад орсноос шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 57,372.6 мянган төгрөгөөр буюу 43 хувиар өссөн байна. Үүнд: түлш халаалт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, урсгал засварын зардал нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Давст сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 150,643.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 150,643.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,181.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 153,825.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх төсвийн хэмнэлтийг нэмж олгосонтой холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 153,825.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 153,825.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 153,825.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 142,738.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 142,738.4 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Давст сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа хороож 8 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, 1 байршуулаагүй мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 325.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 325.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин 78.0 мянган төгрөгийн урсгал зардлыг шууд зардалд бүртгэж тайлагнасныг залрууллаа.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 14.4.1 дэх хэсэгт заасныг зөрчин Татварын хэлтэстэй тооцоо нийлсэн актаар 498.2 мянган төгрөгийн өглөгтэй байсан нь санхүүгийн анхан шатны баримтаар дэмжигдээгүй тул 244.0 мянган төгрөгийн өглөг, 3.7 мянган төгрөгийн авлагыг дутуу бүртгэж тайлагнасныг залрууллаа.

### 5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	325.7	3	325.7						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЭЗ										
	<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>325.7</b>	<b>3</b>	<b>325.7</b>						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Б.ЭНХМАНДАЛ /

2022 оны 02 сарын 21-ний өдөр